

## **Мэс заслын мэргэжлийн зэргийн шалгалт авах журам**

Өнөөгийн манай улсын өөрчлөлт шинэчлэлтийн нэг чиглэл нь хувь хүний нийгэмд үзүүлэх хариуцлагыг өндөржүүлэхэд оршиж буй билээ.

Эрүүл мэндийн ажилд эмч нарын цол, ажилласан жил, хувь хүний мэдлэг чадварыг ялган тэдгээрийн онцлогт тохируулан бүтээлийг нь тооцоход мэс заслын эмч нарын дунд “ахлах” ба “тэргүүлэх”, “зөвлөх” зэргийг тогтоож байхын учир холбогдол оршино.

Мэс заслын эмч нарт ахлах, тэргүүлэх, зөвлөх зэргийг жил бүр дараах мэргэжлийн ялгавараар явуулж байх болно. Үүнд: Мэс заслын ахлах зэргийн эмч 10 жил, тэргүүлэх зэргийн эмч 15 жил, Зөвлөх зэргийн эмч нь 20 жил дагнан мэргэжлээрээ ажилласан, мэргэжил дээшлүүлэх дамжаануудыг дүүргэсэн байна.

### **Зэргийн шалгалтыг 3 үе шаттай явуулна.**

- 1.Мэс заслын зэргийн шалгалтанд орох эмч нарын материал хүлээн авах
- 2.Мэс заслын мэргэжлийн зөвлөлийн ба Нийгэмлэгийн тэргүүлэгчдийн хурлаар шалгалт өгөх эмч нарын материалыг хэлэлцэх
- 3.Мэс заслын эмчээс ахлах, тэргүүлэх, зөвлөх зэргийн шалгалт авах

### **Мэс заслын мэргэжлийн зэргийн шалгалтанд орох эмч нарын материалыг хүлээн авах журам**

- Материалыг мэс заслын эмч нарын нийгэмлэгийн нарийн бичгийн дарга хүлээн авна.
- Жил бүрийн 2сарын 1-ээс 15-ны хооронд материалыг хүлээн авна.
- Зэргийн шалгалтанд орох эмч нарын бүрдүүлэх материал нь:

#### **Нэг. Өргөдөл хүлээн авах**

- 1.Анкет /1-р маягтаар/
  - 2.Ажил байдлын тодорхойлолт /албан газрын даргын тамга, гарын үсэгтэй/
  - 3.Тасаг, хамт олны хурлын протокол
  - 4.Сүүлийн 5 жилд хийсэн ажлын тайлан /тусгай маягтаар (маягт1,2)/
  - 5.Хэвлүүлсэн бүтээлийн жагсаалт /Ахлах зэрэг 5-аас доошгүй өгүүлэл, илтгэл. Тэргүүлэх зэрэг 10-аас доошгүй өгүүлэл, илтгэл/
  6. 2 хувь зураг
- Өгүүлэл, илтгэлийг хувилж хавсаргана.

### **Хоёр. Материалыг нийгэмлэгийн тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэх**

- А. Зэргийн шалгалтанд орох эмч нарын материалыг хүлээн авч дууссанаас хойш 14 хоногийн дотор нарийн бичгийн дарга ангилж танилцуулга бэлдэнэ.
- 1.Шаардлага хангасан.
  - 2.Шаардлага бүрэн хангаагүй
  - 3.Зэргийн шалгалтанд оруулах боломжгүй
- Б. Материал авсанаас 1 сарын дотор нийгэмлэгийн тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж протокол гаргана.
- В.Зэргийн шалгалт авах хугацааг товолно.
- Г.Зэргийн шалгалт авах комиссыг томилно.

### **Гурав. Шалгалт авах**

Мэс заслын ахлах, тэргүүлэх, зөвлөх зэргийн шалгалт авах журам

1. Мэс заслын нийгэмлэгийн хурлаар томилогдсон комисс зарласан товын дагуу шалгалт авна.
2. Шалгалтыг дадлага болон онол хэлбэрээр авна.
3. Дадлага шалгалтыг товын дагуу заагдсан эмнэлгүүд дээр хөтөлбөрт тусгагдсан сэдвийн дагуу өвчтөнг сонгуулж мэс засал хийлгүүлнэ.
4. Онолын шалгалтыг урьдчилан бэлдсэн тест ба амаар товын дагуу томилогдсон комисс авч хариултыг компьютерт оруулж үнэлгээ өгнө.
5. Ерөнхий мэс заслын эмчийн онолын шалгалтын 70% нь ерөнхий мэс засал, 30% нь нарийн мэргэжлийн асуулт байна. Нарийн мэргэжлийн эмчийн 70% нь нарийн мэргэжлийн 30% нь ерөнхий мэс заслын асуулт байна.

### Зөвлөх зэргийн шалгуур

	Шалгуур
<b>Ажилласан жил</b>	25 жилээс дээш
<b>Мэс заслаар</b>	Сүүлийн 20 жил мэс заслаар тасралтгүй ажилласан тэргүүлэх зэрэгтэй байна
<b>Ном товхимол</b>	2, тус бүр 5 хх-аас багагүй
<b>Өгүүлэл</b>	10-аас дээш (зөвшөөрөгдсөн мэргэжлийн сэтгүүлд)
<b>Албан тушаал</b>	Зөвлөх эмч, тасгийн эрхлэгчээр сүүлийн 5-аас доошгүй жил ажилласан байх
<b>Удирдсан эрдэм шинжилгээний ажил</b>	Анагаах ухааны доктор-1 эсвэл 2 магистр удирдаж хамгаалуулсан байна
<b>Эрдмийн цол</b>	Анагаах ухааны доктор хамгаалаад 3-аас доошгүй жил ажилласан байна
<b>Мэргэжлийн чадвар</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Уушигны мэс засал</li> <li>2. Элэг тайрах мэс засал</li> <li>3. Цөсний замын нөхөн сэргээх мэс засал</li> <li>4. Ходоод тайрах мэс засал</li> <li>5. Нарийн, бүдүүн гэдэс тайрах мэс засал</li> <li>6. Нойр булчирхай тайрах мэс засал</li> <li>7. Үнхэлцэг хальсны мэс засал</li> <li>8. Мэдрэлийн- трепанация, нугасны төрөлхийн ивэрхийн мэс засал</li> <li>9. Бөөр шээсний замын нөхөн сэргээх мэс засал</li> </ol>

#### Бүрдүүлэх материал

1. Анкет 1–р маягт
2. Сүүлийн 10 жилийн ажлын тайлан (эмнэлэг, байгууллагын захиргаагаар баталгаажуулсан байх)
3. Хэвлүүлсэн номын хуулбар (эхний 3 нүүр)
4. Хэвлүүлсэн өгүүлэлийн хуулбар (сэтгүүлийн нүүр, гарчиг өгүүлэл )
5. Удирдаж хамгаалуулсан Ph.D, магистрын нэг сэдэвт бүтээлийн хуулбар (нүүр гарчиг)
6. Сүүлийн 5 жилд зөвлөх эмч, тасгийн эрхлэгчээр ажилласан тухай байгууллагын даргын тодорхойлолт.
7. Хамт олны хурлын протокол
8. Ph.D үнэмлэхний хуулбар.
9. Мэс засал хийсэн үзүүлэлтийг зүрх, уушиг, бөөр, мэдрэлийн мэсзасал, элэг тайрах, цөсний замын, ходоод тайрах, нарийн ба бүдүүн гэдэс тайрах, нойр булчирхай тайрах зэрэг мэс заслаар гаргах

#### **Мэс заслын зөвлөх зэргийг жил бүр :**

Ерөнхий мэс заслаар	3	
Мэдрэлийн мэс заслаар	1	
Зүрхний мэс заслаар	1	
Бөөрний мэс заслаар	1	
Бүдүүн гэдэсний мэс заслаар	1	<b>хүртэл эмчийг шалгаруулан олгоно.</b>

#### **I.Ахлах зэргийн эмчийн дадлагын шалгалтаар хийх хагалгааны жагсаалт**

1. Гэдэсний цоорхойг хаах мэс заслын аргууд
2. Гэдэсний түгжрэлийн хагалгаа
3. Ивэрхийн /дахисан ба хагалгааны дараах/ хагалгаа

4. Нарийн ба бүдүүн гэдэс тайрах хагалгаа
5. Панкреатитийн хүндэрсэн хэлбэрт хийгдэх хагалгаа
6. Холецистэктоми /хүндрээгүй тохиолдол/хагалгаа
7. Хэвлийн хөндийн( гэдэс хоорондын, өрцөн доорх, аарцгийн гэх мэт) буглаа
8. Цочмог плеврит, цочмог перикардитийн хагалгаа
9. Элэгний хүндрээгүй бэтгийн хагалгаа
10. Устсан бөөр авах
11. Бөөр шээсний замын чулууны нээлттэй хагалгаа
12. Түрүү булчирхай нээлттэй авах
13. Бөөр, давсаг, шээсний сүв гэмтлийн мэс засал
14. Бөөрний буглааны хагалгаа
15. Бөөрний хатгалттай мэс засал
16. Нээлттэй аргаар бөөрний кистэктоми хийх
17. Давсаг,шээлгүүрийн чулуу бутлах дурангийн мэс засал
18. Плеврийг хуулах мэс засал
19. Торакотоми хийж булез оёх
20. Торакоскопи
21. Шамбарамын хагалгаа(Миллиген-Морган)
22. Архаг парапроктитын хүндрээгүй хэлбэр(Габриэл)
23. Шулуун гэдэсний урвалт-салстын бүтэн урвалтын үеийн тайралт
24. Шулуун гэдэсний сойлтын бүх хэлбэрүүд(хэвлийн ба хязангийн хүрцээр)
25. Хошногоны архаг цууралтын хагалгаа
26. Бүх төрлийн колостомууд

#### **Хүүхдийн мэс засал**

1. Дахисан ивэрхийн хагалгаа
2. Төмсөг буулгах
3. Архаг остеомиелитийн хагалгаа
4. Архаг эмпиемийн хагалгаа
5. Архаг парапроктитийн хагалгаа
6. Наалдцын түгжрэлийн хагалгаа
7. Стоми гаргах
8. Гастростомми
9. Цистостоми
10. Пилоромиотоми
11. Нийлсэн хуруу салгах

#### **II.Тэргүүлэх зэргийн эмчийн дадлагын шалгалтаар хийх хагалгааны жагсаалт**

1. Ходоод тайрах хагалгаа
2. Хүндэрсэн бэтгийн хагалгаа
3. Лапароскопийн хагалгаа
4. Торакоскопийн хагалгаа
5. Цагаан мөгөөрсөн хоолойн хагалгаа
6. Улаан хоолой тайрах хагалгаа
7. Нөхөн сэргээх хагалгаа(бүх эрхтэний)
8. Механик шарын хагалгаа
9. Архаг эмпиемийн хагалгаа
10. Мөч тайрах хагалгаа
11. Бөөрний хавдарын мэс засал(бөөрийг бүхлээр нь авах,хэсэгчилэн авах,тунгалгийн булчирхай, том судасны тромбо авах...)
12. Бөөр шээсний замын нөхөн сэргээх хагалгаа

13. Бөөрний шүр хэлбэрийн чулууг авах мэс засал
14. Бөөрний чулууг дурангаар авах хагалгаа
15. Давсагны хавдарын дурангийн мэс засал
16. Давсаг бүтнээр нь авах мэс засал(радикал цистоэктоми)
17. Радикал простатэктомия
18. Приапизмийн үед сафено-кавернозный шунт үүсгэх мэс засал
19. Түүрүү булчирхай дурангаар авах хагалгаа
20. Бүдүүн шулуун гэдэсний бүх төрлийн тайралтууд
21. Бүдүүн гэдэсний лапароскопийн хагалгаанууд
22. Олон дахисан хүндэрсэн шамбарам
23. Лобэктоми
24. Пульмозэктоми
25. Плевропульмозэктоми
26. Декорткация легкого
27. Өрцний ивэрхий нөхөх
28. Архаг остеомиелитын хагалгаа